



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 715

Улаанбаатар хот

Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашины ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн
715 дугаар тогтоолын хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ДОТООД АЛБАН АЖЛЫН
ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

Д/д	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин (туулах чадвар сайтай)	3
2		Хот доторх ажлын суудлын автомашин (жижиг)	2
3		Хот доторх ажлын жижиг оврын автобус (микро автобус)	1
Нийт автомашин			6